



САНГИЙН ЯАМ

ИРГЭДИЙН ТӨСӨВ - 2019

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ



2018 он
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ



Монгол Улсын Сангийн яамны санаачлагаар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын санхүүжилт, дэмжлэгээр “Иргэдийн төсөв-2019” товхимлыг Монгол Улсын нэгдсэн төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор бэлтгэн гаргав.

Товхимлыг олон нийтийн хүртээл болгох нь бидний зорилго тул бүрэн болон хэсэгчлэн арилжааны бус зорилгоор ашиглаж болно. Ийнхүү ашигласан тохиолдолд эх сурвалжийг “Иргэдийн төсөв-2019”, Сангийн яам гэж тодотгоно уу.

Санал хүсэлт болон мэдээлэлтэй холбоотой лавлах зүйл байвал Сангийн яамны tusuv@mof.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

МЭНДЧИЛГЭЭ



Өрх бүр өөрийн орлого, зарлагаа төлөвлөдөгтэй нэгэн адил Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөв бол Монголчууд бид ямар хэмжээний орлогыг аль салбараас олох, үүнийг ямар бодлоготойгоор юунд зарцуулахыг заасан баримт бичиг юм. Үүнийг иргэддээ ойлгомжтой, нээлттэй, ил тодоор хүргэхийг зорьж “Иргэдийн төсөв-2019” товхимлыг зураг, текст ашиглан жирийн гэр бүлийн хүрээнд хүүрнэж буй яриа хэлбэрээр бэлтгэн Та бүхэндээ хүргэж байна.

Товхимолд төсөв боловсруулахад баримталсан төсвийн бодлого, макро эдийн засгийн таамаглалаас эхлээд төсвийн орлогын эх үүсвэр, Засгийн газрын зээл, тусламж, өрийн мэдээллээс гадна төсвийн зарцуулалтыг салбар бүрээр танилцуулна. Мөн хүүхэд, эхчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагч, малчин иргэдийг төрөөс хэрхэн анхаардаг, тэдэнд төрөөс ямар үйлчилгээ авах боломжтой байдгийг нэгтгэн хүргэж байна.

“Иргэдийн төсөв- 2019” товхимлыг хэвлэмэл байдлаар авч болохоос гадна цахим хэлбэрээр Сангийн яамны цахим хуудас, болон олон нийтийн мэдээллийн сүлжээнээс үзэж болно. Энэ дашрамд товхимлын агуулгыг боловсруулахад оролцсон Сангийн яамны ажилтнууд, санхүүжүүлэн хамтран ажилласан Америкийн Нэгдсэн Улсын Сангийн яаманд гүн талархал илэрхийлж байна.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР

АГУУЛГА



ТӨСВИЙН ТУХАЙ

5

Төсвийн бүрэлдэхүүн, үе шат	6
2019 оны төсвийн бодлого	7
Нэгдсэн төсвийн үзүүлэлт	8



ТӨСВИЙН ОРЛОГО

9

2019 оны төсвийн орлогын бүтэц	10
Төсвийн орлогыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс	11
Татварын шинэчлэл	12
Гаалийн шинэчлэл	13



ТӨСВИЙН ЗАРЛАГА

14

Төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар	15
Төсвийн зарлага салбараар	16
Төсвийн зарлага Төсвийн ерөнхийлөн захирагчаар	18
Засгийн газрын тусгай сан	19
Хөрөнгө оруулалт	20
Засгийн газрын өр	21
Засгийн газрын гадаад зээл, тусламж	22



САЛБАРЫН ТӨСӨВ

26

Боловсрол	27
Эрүүл мэнд	29
Хүрээлэн буй орчин хамгаалал	32
Нийгмийн хамгаалал	34
Эдийн засгийн үйл ажиллагаа	38
Аюулгүй байдал, нийгмийн хэв журам	42
Төрийн нийтлэг үйл ажиллагаа	43
Соёл урлаг, спорт, аялал жуучлал	44



НИЙГМИЙН БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН ТӨСӨВ

45

Хүүхдийг төрөөс хэрхэн анхаардаг вэ?	46
Ахмад настанг төрөөс хэрхэн анхаардаг вэ?	48
Эх хүнийг төрөөс хэрхэн анхаардаг вэ?	50
Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа	51
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс хэрхэн анхаардаг вэ?	52
Малчдыг төрөөс хэрхэн дэмждэг вэ?	53



ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

54

Улс, орон нутгийн төсвийн харилцаа	55
Улаанбаатар хот, 21 аймгийн төсөв, хөрөнгө оруулалт	56

“ИРГЭДИЙН ТӨСӨВ – 2019” ОРОЛЦОГЧ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛ

Ахмад дайчин,
нийгмийн
идэвхтэй гишүүн

Сургуулийн багш
байсан, одоо
тэтгэвэрт гарсан

Иргэдэд төсвийг таниулах үүрэгтэй
Сангийн яамны мэргэжилтнүүд

Төрийн
байгууллагад
ажилладаг

Хувийн салбарт
ажилладаг

Сургуулийн
сурагч

Цэцэрлэгийн
хүүхэд



ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХАА	Хөдөө аж ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ШУ	Шинжлэх ухаан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТУХАЙ

Ээжээ төсөв гэж юу юм бэ?

Аав, ээжийн цалин нь өрхийн орлого болж, түүнийг гэр бүлдээ хэрэгтэй хоол хүнс, байр, боловсрол зэрэгт зарцуулдаг. Харин улсын төсөв гэдэг нь улсын санд хуримтлагдах нийт орлого, түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл юм.

Өрхийн төсөв (сараар)	мянган төгрөг
Орлого	
Аавын цалин	710.0
Ээжийн цалин	790.0
Нийт орлого	1,500.0
Үүнээс: Гэр бүлийн хадгаламж	150.0
Хүүхдийн хадгаламж	50.0
Хадгаламжийн дараах нийт орлого	1,300.0
Зарлага	
Хүнс	350.0
Байрны мөнгө	100.0
Цахилгаан	25.0
Интернэт, утас	55.0
Тээвэр	100.0
Байрны зээл	350.0
Бусад	170.0
Нийт зарлагын дүн	1,150.0
Үлдэгдэл	150.0

Улсын нэгдсэн төсөв	тэрбум төгрөг
Орлого	
Татварын орлого	9,976.3
Татварын бус орлого	1,090.7
Нийт орлогын дүн	11,067.0
Үүнээс: Тогтворжуулалтын санд хуримтлуулах	322.0
Ирээдүйн өв санд хуримтлуулах	1,068.5
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	9,676.5
Зарлага	
Цалин хөлс	2215.2
Цахилгаан, дулаан, ус	1721.6
Зээлийн хүүгийн зардал	865.6
Татаас	261.8
Тэтгэвэр тэтгэмж	3161.7
Хөрөнгө оруулалт	3243.7
Бусад	119.5
Нийт зарлагын дүн	11,589.1
Төсвийн алдагдал	(1,912.6)

ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЕ ШАТ



Улсын төсөв нь боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах гэсэн 4 үе шаттай, 3 жил дамнасан үйл ажиллагаа юм.

Тэгэхээр Монгол Улсын нэгдсэн төсөв нь бүгдийг нь нийлүүлсэн хамгийн том төсөв юм байна.

1 БОЛОВСРУУЛАХ

ЗАСГИЙН ГАЗАР

Ирэх оны төсвийг 10 сарын 1-ний дотор боловсруулж УИХ-д өргөн барьдаг.

2 БАТЛАХ

УЛСЫН ИХ ХУРАЛ

Ирэх оны төсвийг 11 сарын 15-ны дотор УИХ хуульчлан баталдаг.

4 ТАЙЛАГНАХ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Төсвийн гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр тайлагнадаг. Жилийн эцсийн аудитлагдсан тайланг нэгтгэн УИХ-ын хаврын чуулганаар баталдаг.

3 ХЭРЭГЖҮҮЛЭХ


САНГИЙН ЯАМ

Тухайн оны 1 сарын 1-ээс эхлэн төсөв зарцуулах эрх нээгдэж, 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болдог.



2019 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГО


Засгийн газраас 2019 оны төсвийг боловсруулахдаа дараах бодлогыг баримталсан.




- ТӨСВИЙН ТЭНЦЭЛ**
Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 5.4%-д хүргэнэ.
- ТӨСВИЙН ОРЛОГО**
Татварын хуулийн шинэчлэл, Гаалийн шинэчлэл, Орон нутгийн орлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
- ТӨСВИЙН ЗАРЛАГА** - Төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, үр ашигтай хуваарилахад технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ил тод байдлыг сайжруулна.
- ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** - Нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
- ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ**
Гадаадын зээл, тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн үр ашигтай төсөлд зарцуулна.
- ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР** - Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг 55.3% болгож, хүүгийн зардлыг бууруулна.
- ОРОН НУТГИЙН ТӨСӨВ** - Төсвийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн өмчийг эзэнд нь хариуцуулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

Эдийн засаг 2019 онд 8%-иар өсөх, ажилгүйдлийн түвшин 0.5 пунктээр буурах сайн үзүүлэлттэй байна.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН



ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ




ИНФЛЯЦИЙН ТҮВШИН



НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ




Манай улсын төсөв 1960 онд анх удаагаа тэрбумд, 2006 оноос их наядаар тоологдох хэмжээнд хүрсэн бол 2019 онд төсөв анх удаа 10 их наядыг давж байна.



Хэрвээ би буруу ойлгоогүй бол 2019 оны төсвийн зарлага нь орлогоосоо давсан байна тийм үү?

Яг зөв бодсон байна. Төсвийн орлого, зарлагын зөрүүг тэнцэл гэдэг бөгөөд 2019 онд төсвийн алдагдал 1.9 их наяд төгрөг байна. Гэхдээ төсвийн зөв бодлого явуулсны үр дүнд төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь буурч байгааг энэ сүүлийн 5 жилийн мэдээллээс харж болно.

2015 гүйц 2016 гүйц 2017 гүйц 2018 батлагдсан 2019 батлагдсан



БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГО



Улсын төсвийг бүрдүүлдэг газрыг
Татварын алба гэдэг юм.

Ааваа Татварын
алба гэж юу?



Төсвийн орлогын ихэнх хэсгийг татварын
орлогоос бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл аав,
ээжийнх нь цалин, аж ахуйн нэгжийн орлогоос
албан татвар хурааж улсын төсөв бүрдэнэ.

Төсвийг яаж
бүрдүүлдэг юм бол?



Ахынх нь дэвтэр, миний охины чихрийг
авахад хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвар
төлж байдаг. Иймд улсын төсөв бүх
иргэдэд хамааралтай.




БИЗНЕС ТӨВ

ТАТВАРЫН АЛБА

ИХ ДЭЛГҮҮР

БАНК




2019 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн орлогоор тооцдог. Төсвийн нийт орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санд хуваарилаад үлдэх хэсгийг Төсвийн тэнцвэржүүлсэн орлого гэнэ.



Ирээдүйн өв сан гэж уул уурхайн салбараас төсөвт төвлөрч буй орлогын тодорхой хэсгийг ирээдүй хойч үедээ зориулан хадгалж буй санг хэлнэ. Монгол Улс түүхэндээ анх удаа 2019 онд Ирээдүйн өв сандаа 553.0 тэрбум төгрөгийн хуримтлалыг үүсгэнэ.

Ирэх 2019 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 9,676.5 тэрбум төгрөгөөр баталсан. Үүнийг орлогын төрлөөр харуулъя.



ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС



2019 оны төсвийн орлого яагаад 3,204 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн юм бэ?




Манай орны төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд уул уурхайн салбарын орлого болон эдийн засаг 8%-иар өсөж байгаа зэрэг нь гол хүчин зүйл болсон.

ОРЛОГЫН НИЙТ ӨСӨЛТ
3,204 тэрбум төгрөг



Уул уурхайн салбараас ирэх онд 3,000 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрнө. Үүний 1,311 тэрбум төгрөгийг нүүрснээс, 1,304 тэрбум төгрөгийг зэсийн баяжмалаас оруулах нь дийлэнх хэсгийг эзэлж байна.



НҮҮРС	АЛТ	ЗЭСИЙН БАЯЖМАЛ
<ul style="list-style-type: none"> Хэмжээ: 42 сая тонн Үнэ: 75-130 ам.доллар/тонн 	<ul style="list-style-type: none"> Хэмжээ: 21 тонн Үнэ: 1,262 ам.доллар/унци 	<ul style="list-style-type: none"> Хэмжээ: 1400 мянган тонн Үнэ: 6,272 ам.доллар/тонн
1,311 тэрбум ▲ 165% 2018 оноос	83 тэрбум ▲ 3% 2018 оноос	1,304 тэрбум ▲ 30% 2018 оноос

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ




Татварын шинэчлэл хийснээр бизнес эрхлэгчид ямар ач холбогдолтой вэ?



Шинэчлэлийн гол зорилго нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих юм.

Одоогийн хуульд жилийн ашиг 3 тэрбум хүртэл 10% татвар, дээш бол 25% татвар төлж, улирал бүр тайлагнадаг (жилд 4 удаа).



Хуулийн төсөлд Компаний ашгаас хамаарч төлөх хувь хэмжээг бууруулж, хөнгөлөлт эдэлнэ. Мөн тайлангийн тоог цөөрүүлсэн.

- Жилд тайлагнах тайлангийн тоо

- Татварын хувь хэмжээ



Иргэдэд ямар ач холбогдолтой хуулийн шинэчлэл вэ?



Хувь хүний орлогын албан татварт иргэдийг дэмжсэн олон заалтууд орсноос хамгийн амьдралд ойр байгааг та бүхэнд тайлбарлая.

Ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон тус зээлийн хүүгийн зөрүүгээр татварын хөнгөлөлтийг эдлэх боломжийг олгоно.

Жилийн 50 саяас бага борлуулалтын орлоготой бол жилд 1 удаа тайлагнана.

~~10%~~ 1%

Орон сууц анх удаа худалдаж авахад үзүүлдэг татварын хөнгөлөлт

~~3 сая~~ 6 сая

ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛ



Улсын төсвийг бүрдүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангахад Гаалийн татвар маш чухал үүрэгтэй. Төсвийн орлогын 26.6 хувийг бүрдүүлдэг гаалийн орлогыг бид тэр бүр зөв, тодорхойлж бүрэн цуглуулж чадахгүй байна. Дараах тулгамдсан асуудлууд байсаар л байна.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

1

Улсын хилээр хууль бусаар ашигт малтмал тээвэрлэх

Ашигт малтмалын агуулгын мэдээллийг зөрүүтэй гаргах

Ашигт малтмалын дагалдах бүтээгдэхүүнээс татварын орлогыг дутуу тооцож ногдуулах

Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо хэмжээ зөрүүтэй байх

Шаардлага хангахгүй бүтээгдэхүүн импортлож хэрэглэгчдийн эрх ашгийг хохироох

Хилийн боомтоор гаалийн мэдүүлэггүй ашигт малтмал тээвэрлэх



Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газраас гаалийн шинэчлэлийг хийнэ. Хэрэгжүүлэх ажил, гарах үр дүнг тайлбарлая.

2

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

Хилийн боомт бүрийг шилэн кабельд холбон Гаалийн ерөнхий газрын дэргэд Шуурхай хяналт, удирдлагын төв байгуулна.

Гаалийн хяналтын нэгж, цэг бүрийг автомат телехяналтын системд хамруулж хууль бусаар бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх, татвараас зайлсхийх явдлаас сэргийлнэ.

Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим бүртгэлийн "Ухаалаг гарц" системийг нэвтрүүлнэ.

Орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген тоног төхөөрөмж, метал илрүүлэгч, үнэрч нохой болон бусад тоног төхөөрөмжүүдээр хилийн боомтуудыг үе шаттайгаар хангана

Төрөлжсөн орчин үеийн цахим болон шинжилгээний лабораториудыг 2019 оноос үе шаттай байгуулна. Лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэчилнэ.

Импортын барааг эцсийн хэрэглэгч хүртэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс экспортод гарах хүртэлх бүртгэлийг олон улсын стандарт кодчлолыг ашиглан хэрэгжүүлнэ.



Үнэхээр цогц, иж бүрнээр асуудлыг шийдвэрлэх юм байна. Өнөөдрийн хөрөнгө оруулалт, ирээдүйн төсвийн бүрдэлтийг нэмэгдүүлэхэд үнэхээр ач холбогдолтой шинэчлэл болох нь ээ.

3

ХҮРЭХ ҮР ДҮН

Экспортоор гарч буй байгалийн баялгийг үнэн зөв тодорхойлж, татварыг бүрэн хураана.

Гаалийн хяналт, шалгалт сайжирч, бүрдүүлэлтийн хугацаа багасаж, төсвийн орлого нэмэгдэнэ.

Импортоор хууль бус, чанаргүй бараа хилээр нэвтрэхгүй болж иргэдийн эрх ашгийг хамгаална.

Технологийн дэвшлийг нэвтрүүлэн хил гаалийн үйлчилгээ түргэн шуурхай болж иргэдийн зардал багасна.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГА



Улсын төсвийг юунд зарцуулдаг вэ?

Ард иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, боловсрол олгох, соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх, зам гүүр барих гээд олон хэрэгтэй зүйлд зарцуулдаг. Харин иргэн бүр төсвийн талаар мэдээлэлтэй байж хяналт тавих үүрэгтэй.





Яагаад төсвийн зарцуулалтанд иргэд хяналт тавих ёстой гэж?

Яагаад гэвэл төсөв нь иргэдийн төлсөн татвараас бүрддэг тул бид хяналт тавих ёстой.



Хэрэв мөнгөө буруу тооцоолж, хэрэггүй, шаардлагагүй зүйлд зарцуулаад байвал улс орон хөгжихгүй бас өрөнд унана. Иймд иргэн бүр төсвийн талаар мэдээлэлтэй байж, хяналт тавьж чаддаг байх ёстой.



ТӨСВИЙН ЗАРЛАГА ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

Төсвийг эдийн засгийн ангиллаар урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх цэвэр зээл гэж ангилдаг.




Энэ жилийн төсвийн зардал өмнөх оноос яагаад 1,937.6 тэрбум төгрөгөөр өсч байгаа юм бэ?







Энэ онд нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр хөрөнгө оруулалтын зардлыг 1,315.2 тэрбум, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд 558.8 тэрбум төгрөг зарцуулахтай холбоотой юм.

Шинээр нэмэгдэж байгаа зардлын өөрчлөлт, арга хэмжээгээр (тэрбум төгрөг)



ТӨСВИЙН ЗАРЛАГА САЛБАРААР

	БОЛОВСРОЛ	ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН ХАМГААЛАЛ	АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ
	 <p>Цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсрол дээд боловсрол болон шинжлэх ухааны байгууллага</p>	 <p>Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа</p>	 <p>Байгаль орчин болон байгалийн нөөц баялгийг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ</p>	 <p>Зэвсэгт хүчин, хил хамгаалах, шүүх, прокурор, цагдаа, онцгой байдал</p>
	1,897.3 ▲ 32.9% 2018 он	949.3 ▲ 47.9% 2018 он	196.0 ▲ 79.9% 2018 он	1,067.0 ▲ 19.6% 2018 он
Нийт зардал, салбар тус бүрээр	Сургуулийн өмнөх боловсрол	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр	Ойжуулалт, ус, гол мөрний менежмент	Зэвсэгт хүчин
	Ерөнхий боловсрол	Эрчим хүч, уул уурхай	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	Хил хамгаалах
	Дээд боловсрол	Зам тээвэр	Агаарын бохирдлыг бууруулах	Шүүх, прокурорын байгууллага
	Мэргэжлийн боловсрол	Хот байгуулалт, нийтийн аж ахуй	Ус цаг уур, орчны шинжилгээ	Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл
	Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага, хөрөнгө оруулалт	Худалдаа	Хүрээлэн буй орчны бодлого, судалгаа	Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах
	Харилцаа холбоо	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	
	Хөдөлмөр эрхлэлт		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	
			Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдал удирдлага, судалгаа шинжилгээ	

Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал орсон.

ТӨРИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, орон нутгийн байгууллагын зардал болон гадаад зээл, тусламжаар хэрэгжих төсөл, Засгийн газрын зээлийн хүүгийн зардал

1,444.9 ▲ **28.3%**
2018 он

Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, орон нутгийн удирдлага	451.6
Ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаа	616.4
Гадаад харилцаа	76.3
Төрийн нийтлэг бусад үйлчилгээ	167.3
Засаг захиргааны түвшин хоорондын шилжүүлэг	133.4

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр

1,242.3 ▲ **30.6%**
2018 он

Зээлийн үйлчилгээний төлбөр

865.6 ▼ **24.8%**
2018 он

ЭРҮҮЛ МЭНД



Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн даатгал

1,021.2 ▲ **23.7%**
2018 он

Эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд	716.3
Эрүүл мэндийн бодлого, удирдлага	150.5
Эрүүл мэндийн даатгал	154.4

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



Нийгмийн даатгал, халамж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд

2,889.9 ▲ **13.1%**
2018 он

Нийгмийн даатгал	2,068.5
Нийгмийн халамж	726.1
Нийгмийн хамгааллын бодлого удирдлага	3.8
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	61.6
Нийгмийн хамгааллын хөрөнгө оруулалт	29.9

СПОРТ, СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ




Театр, чуулга, номын сан, музей, соёлын байгууллага болон спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагаа

245.3 ▲ **64.4%**
2018 он

Биеийн тамир спорт	75.4
Соёл урлаг	163.3
Аялал жуулчлал	6.6

Төсвийг эдийн засгийн ангиллаас гадна Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлээр дээрх салбараар харуулж болдог.



ТӨСВИЙН ЗАРЛАГА ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР



Урсгал зардал	Хөрөнгийн зардал	Гадны зээл тусламж	Эргэж төлөгдөх цэвэр зээл	Нийт дүн	
6,360.3 тэрбум	1,796.9 тэрбум	1,242.3 тэрбум	7.1 тэрбум	9,406.6 тэрбум	
ТӨС		ТӨСВИЙН БҮТЭЦ (тэрбум төгрөг)		Нийт	
Сангийн сайд	1,320.6	134.4	1,242.3	-4.3	2,693.0
БСШУС-ын сайд	1,192.3	616.5	49.8		1,858.6
ХНХ-ын сайд	1,585.5	33.9			1,619.4
Эрүүл мэндийн сайд	735.7	104.2			839.9
ХЗДХ-ийн сайд	495.5	42.9	-20.6		517.8
Монгол Улсын Ерөнхий сайд	101.5	206.5			308.0
Батлан хамгаалахын сайд	245.8	15.5			261.3
Зам, тээврийн хөгжлийн сайд	9.5	241.8			251.3
Барилга хот байгуулалтын сайд	17.0	141.4	5.0		163.4
Монгол Улсын Шадар сайд	132.6	14.4			147.0
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	74.3	19.5	49.0		142.8
Эрчим хүчний сайд	18.9	97.2			116.0
ХХААХҮ-ийн сайд	133.8	42.3	-71.8		104.4
Гадаад харилцааны сайд	73.4	2.9			76.3
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	23.2	38.7			61.9
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	50.3	0.8			51.1
Монгол Улсын Их Хурлын дарга	38.4	2.0			40.4
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	12.3	26.6			38.9
Улсын ерөнхий прокурор	30.0	4.4			34.4
Авлигатай тэмцэх газрын дарга	16.3	0.8			17.1
Монгол Улсын Ерөнхий аудитор	14.0	1.5			15.5
Үндэсний статистикийн хорооны дарга	10.2				10.2
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	6.0	4.0			10.0
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	5.6				5.6
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	1.1	4.0			5.1
Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар	4.6				4.6
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	3.8				3.8
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	3.5	0.2			3.8
Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцийн дарга	2.2	0.5			2.7
Төрийн албаны зөвлөлийн дарга	1.3				1.3
Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	1.1				1.1


ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН

Засгийн газрын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хуулийн дагуу байгуулагдсан санг Засгийн газрын тусгай сан гэнэ. Дээрх сангийн эх үүсвэр болон зарцуулалтыг хуулиар зааж өгсөн байдаг.




Харьяа яамд	Засгийн газрын тусгай сангууд	2019 онд (тэрбум төгрөгөөр)			2018 оноос
		Улсын төсвөөс	Өөрийн орлогоос	Нийт	
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Боловсролын зээлийн сан	76.5		76.5	▼35.7%
	Шинжлэх ухаан, технологийн сан	12.6	0.02	12.6	▲0.3%
	Соёл, урлаг хөгжүүлэх сан	2.0		2.0	
	Спортыг дэмжих сан	2.0		2.0	▼33.3%
	Монгол судлалыг дэмжих сан	0.9		0.9	
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Нийгмийн даатгалын сан	605.5	1,463.0	2,068.5	▲14.4%
	Нийгмийн халамжийн сан	694.5		694.5	▲7.1%
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	28.5	54.9	83.4	▲27.6%
	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	8.0	41.0	49.0	▲618.8%
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Тариаланг дэмжих сан	13.0	39.0	52.0	▼21.2%
	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	47.0	1.0	48.0	▼51.6%
	Мал хамгаалах сан	34.5	1.8	36.3	▼1.0%
Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн даатгалын сан		407.7	407.7	▲19.4%
	Эрүүл мэндийг дэмжих сан	3.0		3.0	▼40.0%
Гадаад харилцааны яам	Олон улсын хамтын ажиллагааны сан		1.0	1.0	
	Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан	0.2		0.2	
Батлан хамгаалах яам	Зэвсэгт хүчний хөгжлийн сан		35.0	35.0	▼12.5%
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, уур амьсгалын сан	1.9		1.9	
Зам, тээврийн хөгжлийн яам	Улсын авто замын сан		2.2	2.2	
Хууль зүй, дотоод хэргийн яам	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан		0.6	0.6	
Сангийн сайд	Засгийн газрын нөөц сан	25.0		25.0	
Засгийн газрын хэрэг эрхлэх	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	2.1		2.1	▼15.6%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Энэ онд хөрөнгө оруулалтыг ямар чиглэлээр хийх вэ?

Энэ онд эдийн засаг, нийгмийн үр ашигтай, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээнд хөрөнгө оруулна.



Гаалийн бүртгэл, хяналтын тогтолцоог бэхжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид бүрэн шилжүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.

Анхан шатлалын эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар, хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдийн ачааллыг бууруулна.

Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталж зарцуулна.



“Барих-Шилжүүлэх” 12 төслийн концессийн эргэн төлөлтөд зарцуулна.

Ойжуулалт, нөөц хөрөнгө бэлтгэх зэрэг бусад хөрөнгийн зардалд ашиглагдана.

Нийт 1281 төсөл арга хэмжээнд зарцуулна.

Олон улсын гэрээ хэлэлцээрт туссан арга хэмжээнд зарцуулна.

- Хэрэгжих томоохон ажлууд:**
- 176 Цэцэрлэг
 - 124 Сургууль
 - 84 Авто зам
 - 72 Эмнэлэг
 - 57 Соёлын төв
 - 42 Дотуур байр
 - 23 Гүүр
 - 12 Спорт цогцолбор


НИЙТ ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ
3,247.7 тэрбум төгрөг

- Хэрэгжих томоохон ажлууд:**
- Төв цэвэрлэх байгууламж
 - Цэвэрлэх байгууламж (7 аймагт)
 - Хатуу хог, хаягдал боловсруулах үйлдвэр
 - Үндэсний оношлогоо эмчилгээний төв
 - Түлэнхийн төв
 - Газрын тос боловсруулах үйлдвэр барих, дамжуулах хоолой татах
 - Дулааны станц (10 аймагт)
 - Улаанбаатар-Дархан-Алтанбулаг 311 км зам
 - Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж (4 аймагт)


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР




Засгийн газрын өрийн хэмжээ буурч байна гэнээ.
Энэ чинь харин сайн мэдээ байна даа.



Өрийг үе шаттай бууруулах бодлого баримталсны үр дүнд 2016 онд ДНБ-ны 78.8 хувьд хүрээд байсан Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнэ 2019 онд 55.3 хувь болж буурна.



Мөн өндөр хүүтэй үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авч, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг сайжруулснаар хүүгийн зардлыг бууруулж байна. Үүний үр дүнд 2018 онд төсвийн зардлын 8 төгрөг туйтмын 1 төгрөгийг хүүгийн зардалд өгч байсан бол 2019 онд 13 төгрөг туйтмын 1 төгрөг болж буурах юм.



Өр нэмэгдвэл яах вэ?


Өр нэмэгдэх нь дараах сөрөг үр дагавартай.



Төсвийн зарлага нь орлогоосоо давах үед түүнийг төсвийн алдагдал гэж нэрлэх ба төсвийн алдагдлыг Засгийн газар дотоодын арилжааны банк, гадаадын олон улсын байгууллагаас мөнгө зээлж санхүүжүүлснээр өр үүсдэг.



Их хэмжээний өр тавьснаар цалин, тэтгэвэр, цэцэрлэг, сургуульд зарцуулж болох байсан мөнгийг өрийн хүүгийн төлбөрт зарцуулдаг.



Өндөр хөгжсөн Япон, Америк, Герман зэрэг орноос авахуулаад хөгжиж буй Эстони, Турк зэрэг дэлхийн ихэнх орны Засгийн газрууд өр тавьж, алдагдлыг санхүүжүүлдэг.

Өрийн хэмжээ их байх нь төсөв болон эдийн засагт сөрөг нөлөөтэй бөгөөд бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхэд хүртэл нөлөөлдөг.

Өр зээл нь нөхцөлөөсөө шалтгаалж, гадаад валютын ханшийн эрсдэл, өрийн эргэн төлөлтийн эрсдэл, хүүгийн эрсдэл үүсч байдаг.



Их хэмжээний өрийн дарамтад орох буюу өрөө төлж чадахгүй болбол Үндэсний аюулгүй байдал алдагдана.

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ



Хөгжлийн албан ёсны тусламж гэж юу вэ?
Энэ нь ямар ач холбогдолтой вэ?



Монгол Улсын хөгжлийг дэмжих зорилгоор гадаад улс болон олон улсын байгууллагаас Засгийн газарт олгож буй буцалтгүй тусламж болон хөнгөлөлттэй зээл юм. Энэ нь тухайн улсад мэдлэг, технологи, санхүүжилт болон бусад олон хэлбэрээр үр өгөөжөө өгдөг.



Тэгвэл манай орон ямар чиглэлээр хэдэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа вэ?

Нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамж, дэд бүтцийг сайжруулах

Нийт 469.3 тэрбум төгрөг
Зээл 454.3
Тусламж 15.0 **38%**

Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах

Нийт 224.3 тэрбум төгрөг
Зээл 171.0
Тусламж 53.3 **18%**

Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих

Нийт 253.7 тэрбум төгрөг
Зээл 219.0
Тусламж 34.7 **20%**

Бизнесийн орчинг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих

Нийт 183.1 тэрбум төгрөг
Зээл 169.2
Тусламж 13.9 **15%**



Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2019 онд нийт 132 төсөл, арга хэмжээг 1,242.3 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлнэ.

Бусад чиглэлийн төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүн

Нийт 111.8 тэрбум төгрөг
Зээл 82.8
Тусламж 29.1 **9%**

НИЙТ ЗЭЭЛ ТУСЛАМЖ

1,242.3 тэрбум төгрөг

Нийт зээл 1,096.3

Нийт тусламж 146.0

100%


ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГААС ОЛГОЖ БҮЙ ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Тэгвэл зээл, тусламж хоёр юугаараа ялгаатай юм бэ?



Буцалтгүй тусламж гэдэг нь гадаад улс, олон улсын байгууллагаас эргэн төлөх нөхцөлгүй олгож буй санхүүжилтийг хэлнэ. Мөн бараа бүтээгдэхүүн, хүмүүнлэгийн тусламж ордог.

Харин, хөнгөлөлттэй зээл нь эргэн төлөгдөх нөхцөлтэй. Гэхдээ арилжааны зээлээс ялгагдах үндсэн онцлог нь зээлийн хугацаа урт, хүү бага, үндсэн болон хүүгийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа урт байх зэрэг таатай нөхцлүүдтэй байдаг. “Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль”-д зааснаар зээлийн хэлэлцээрийг УИХ соёрхон баталдаг.




НИЙТ 1,242.3 тэрбум

Хөнгөлөлттэй зээл
91 төсөл

Буцалтгүй тусламжаар
41 төсөл

Монгол Улсын 2019 оны төсөвт туссан нийт зээл, тусламжийг хөгжлийн түнш байгууллагаар харуулбал:



Бусад хөгжлийн түншлэгчийн санхүүжилтээр дараах тооны төслүүд хэрэгжиж

- *Мянганы сорилтын корпораци - 1
- *Бельгийн Вант Улсын Засгийн газар - 1
- *БНФУ-ын Засгийн газар - 1
- *Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан - 1
- *Европын сэргээн босголт, хөгжлийн банк - 1
- *Беларусь - 2
- *БНУУ-ын Засгийн газар - 1

- *Нэгдсэн Үндэстний байгууллага - 1
- *Люксембургийн Вант Улс - 1
- *Швейцарийн хөгжлийн агентлаг - 2
- *Австри Улсын Засгийн газар - 5
- *Польш Улсын Засгийн газар - 6
- *Кувейт Улсын Засгийн газар - 2

БҮЛЭГ 4. САЛБАРЫН ТӨСӨВ

Төсвийг үйл ажиллагааны чиглэлээр нь 8 салбарт хуваан Та бүхэндээ танилцуулж байна.

БОЛОВСРОЛ



Төрөөс бидний боловсролд хэрхэн анхаардаг вэ?

ЭРҮҮЛ МЭНД



Хайртай гэл бүлийн минь эрүүл мэндэд хэрхэн анхаардаг вэ?

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН ХАМГААЛАЛ



Амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэхэд хэрхэн анхаардаг вэ?

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



Эрсдэлд өртөмтгий бүлгийг хэрхэн хамгаалдаг вэ?

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Бидний ирээдүйн төлөө улс орноо хөгжүүлэхэд хэрхэн анхаардаг вэ?

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ



Биднийг айх аюулгүй, амгалан тайван амьдрахад яаж анхаардаг вэ?

ТӨРИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА




Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэхэд хэрхэн анхаардаг вэ?

СОЁЛ УРЛАГ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Эрүүл чийрэг иргэн болж, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөхөд хэрхэн анхаардаг вэ?

БОЛОВСРОЛ



Төсвийн онцлог, 2019 онд

ЕБС-ийн хичээлийн 3 ээлжийг 2 ээлжид шилжүүлэх “3 ээлжгүй сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийн хүрээнд хот суурин газарт цэцэрлэгийн насны хүүхдийг бүрэн хамрагдах нөхцлийг бүрдүүлнэ.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсад сар бүр 100,000 төгрөгийн тэтгэлэг олгоно.

Оюутны хөгжлийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ



Би улсын цэцэрлэгт явдаг. Төрөөс бидний зардлыг 100 хувь дааж, үнэ төлбөргүй хамруулдаг.



Төсөв (тэрбум төгрөг)	Улсын цэцэрлэг	Хувийн цэцэрлэг
	301.5	33.0
Хүүхдийн тоо	277,990	40,293
Цэцэрлэгийн тоо	983	554
Багш, ажилчдын тоо	22,391	5,247

Хувийн цэцэрлэгийн нэг хүүхдэд нэг жилд 807,800 - 998,200 төгрөгөөр тооцож санхүүжилт олгодог.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ



Би улсын сургуульд сурдаг. Төрөөс ерөнхий боловсролыг төрийн өмчит сургуулиар үнэгүй олгодог.



Төсөв (тэрбум төгрөг)	Улсын сургууль	Хувийн сургууль
	684.6	1.2
Хүүхдийн тоо	625,970	39,361
Сургуулийн тоо	720	169
Багш, ажилчдын тоо	46,514	4,985

Хувийн сургуульд сургалтын төлбөрөөс хамаарч хүүхдийн тоогоор 86,700 - 459,300 төгрөгийн санхүүжилтийг жилд 1 удаа олгодог.

Хүүхэд харах үйлчилгээ: 3.9 тэрбум төгрөг

Хүүхдийн тоо: 5,308

Хүүхэд харах төвийн тоо: 431

Хамрагдаж буй иргэнд нэг жилд хувьсах зардал, хоолны зардлыг төрөөс олгодог.

Хүүхдийн хоол: 62.6 тэрбум төгрөг

Хүүхдийн тоо: 204,422

Энгийн цэцэрлэгт өдрийн 1,650 төгрөг, сувиллын болон тусгай цэцэрлэгт өдрийн 2,400 төгрөг.

Хувьсах зардал (1 хүүхдэд 1 жилд)

Сумын цэцэрлэг: 998,200 төгрөг
Аймгийн төвд: 812,300 төгрөг
Нийслэлд: 807,800 төгрөг

Үдийн цай хөтөлбөр: 34.2 тэрбум төгрөг

Хүүхдийн тоо: 341,969

1-5-р ангийн хүүхдүүдэд өдөрт 600 төгрөг, тусгай хэрэгцээт сургуулийн сурагчид өдөрт 2,400 төгрөгийн үдийн цай өгдөг.

Дотуур байр: 52.8 тэрбум төгрөг

Хүүхдийн тоо: 39,264

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох зардал 312,700 - 462,200 төгрөг.

Сурах бичиг: 3.7 тэрбум төгрөг

2019 оноос сурах бичгийг түрээслүүлж, орлогоороо нөхөн хэвлэлт хийдэг сурах бичгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ



Мэргэжлийн боловсрол эзэмшиж байгаа суралцагчдад төрөөс сар бүр 100,000 төгрөгийн тэтгэлэг олгож эхлэнэ.

Нийт төсөв:
108.3* тэрбум
193% 2018 он
төгрөг

Мэргэжлийн боловсролын салбарт (тэрбум төгрөгөөр)



* тэтгэлгийн зардал орсон дүн

БОЛОВСРОЛ, ШУ-НЫ БОДЛОГО, УДИРДЛАГА

Нийт төсөв: **61.6** тэрбум
төгрөг 18.2% 2018



БСШУСЯ, түүний харъяа, эрдэм шинжилгээний байгууллагууд албан бус боловсролыг төрөөс байнга дэмжин ажилладаг.

Шинжлэх ухаан, технологи	38.4	тэрбум
Насан туршийн болон албан бус боловсрол	4.2	тэрбум
Тусгай хэрэгцээт боловсрол	4.1	тэрбум
Боловсрол, ШУ-ны бодлого, удирдлага	14.9	тэрбум

ДЭЭД БОЛОВСРОЛ



Гадаад болон дотоодын их, дээд сургуульд суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, зарим тэтгэлэг олгодог.



Гадаадад сурч буй оюутнуудад (тэрбум төгрөгөөр)

ЗГ-ын гэрээгээр гадаадад суралцагчид олгох зээл	7.3
Гадаадад суралцагчдын зардал	3.5
Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл	14.5

Дотоодод сурч буй оюутнуудад (тэрбум төгрөгөөр)

Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг	0.9
Нэн ядуу, малчин, зарим суралцагчдад сургалтын төлбөрийн тэтгэлэг	12.6
Орон нутгаас суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт	1.0
Багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантад сургалтын төлбөр	2.8
Орон нутгийн багшлах дадлагын тэтгэлэг	0.5
Сургалтын төлбөрийн зээл	33.0
Оюутны нийтийн тээврийн хөнгөлөлт	5.7

ЭРҮҮЛ МЭНД



Ааваа, эмч сая намайг үзээд яагаад төлбөр аваагүй юм бэ?




Эрүүл мэндийн даатгал гэж юу вэ?



Хүүхдүүд болон өвөө, эмээ шиг нь ахмад настан болон зарим хүмүүсийн эрүүл мэндийн даатгалыг төр хариуцдагтай холбоотой.



Эрүүл мэндийн даатгал нь эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан байдаг тул иргэд тогтоосон хэмжээгээр шимтгэл төлж, төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг даатгалын санхүүжилтээр авах боломжтой байдаг.



Зарим эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.

Эрүүл шүд – Эрүүл хүүхэд хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

Анхан шатлалын тусламж, үйлчилгээг сайжруулна.



ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД

2019 онд 10 эмнэлгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, төсвийн уян хатан зохицуулалтыг бий болгоно. Ингэснээр дараах давуу талтай.



Төсөв санхүүгийн оновчтой хуваарилалт хийнэ.

1

Авсан санхүүжилтээ уян хатан зохицуулна.

2

Эмч, эмнэлгийн ажилтнуудын орон тоог оновчтой зохион байгуулна.

3

Ажлын ачаалалтай уялдсан нэмэлт цалин, урамшуулал олгох боломжтой.

4

- Улсын гуравдугаар төв эмнэлэг
- Арьсны өвчин судлалын үндэсний төв
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- Гэмтэл, согог судлалын үндэсний төв

- Нийслэлийн Өргөө амаржих газар
- Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв
- Төв аймгийн нэгдсэн эмнэлэг
- Увс аймгийн нэгдсэн эмнэлэг
- Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг

Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага

Өрхийн эрүүл мэндийн төв



Нийт 223

33.1 тэрбум **▲ 13%** 2018 оноос

Жилд дунджаар 6 сая орчим иргэнд үйлчилдэг.

Сумын эрүүл мэндийн төв



Нийт 329

134.6 тэрбум **▲ 33.9%** 2018 оноос

Жилд дунджаар:

- Амбулатори: **8 сая**
- Хэвтэн эмчлүүлэх: **114 мянга**

Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага

Дүүргийн нэгдсэн эмнэлэг



Нийт 12

70.4 тэрбум **▲ 27.2%** 2018 оноос

Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг



Нийт 6

13.0 тэрбум **▲ 17.5%** 2018 оноос

Аймгийн нэгдсэн эмнэлэг



Нийт 16

110.5 тэрбум **▲ 20.8%** 2018 оноос

Жилд дунджаар:

- Амбулатори: **2.4 сая**
- Хэвтэн эмчлүүлэх: **105 мянга**

Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага

Бүсийн оношлогоо, эмчилгээний төв



Нийт 5

42.9 тэрбум **▲ 18.1%** 2018 оноос

Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв



Нийт 13

233.2 тэрбум **▲ 17%** 2018 оноос

Жилд дунджаар:

- Амбулатори: **2 сая**
- Хэвтэн эмчлүүлэх: **205.5 мянга**

Эрүүл мэндийн байгууллага

Нийслэлийн амаржих газар



Нийт 3

21.5 тэрбум **▲ 25.4%** 2018 оноос

Бусад байгууллага



Нийт 28

33.4 тэрбум **▲ 17.8%** 2018 оноос

Эрүүл мэндийн арга хэмжээ, үйлчилгээ

Гемодиализийн төлбөр



3.2 тэрбум **▲ 5.4%** 2018 оноос

Товлолт вакцинжуулалт



9.9 тэрбум **▲ 11.2%** 2018 оноос

Эрүүл шүд- Эрүүл хүүхэд хөтөлбөр



4.7 тэрбум **▲ Шинэ** 2018 оноос

Эрүүл мэндийн бодлого, удирдлага



25.9 тэрбум **▲ 37%** 2018 оноос

Удирдах байгууллагуудын үйл ажиллагааны зардал



17.8 тэрбум **▼ 34%** 2018 оноос

Тэтгэвэрт гарахад болон орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж **2885 хүн**


Хөрөнгө оруулалт



104.2 тэрбум **▲ 61.4%** 2018 оноос

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр 407.7 тэрбум төгрөгийг төсөвлөөд байна.




ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН ХАМГААЛАЛ



Ээжээ, өнөөдөр багш бидэнд агаарын бохирдол хүний биенд ямар хортой талаар ярьж өгсөн. Мөн мод, ногоон байгууламж хортой хийг өөртөө шингээж, хүчилтөрөгч ялгаруулдаг гэсэн.



Яг зөв, байгаль эх зөвхөн амьсгалах агаар, уух усаар хангах төдийгүй, бид бүхний хоол хүнс, хувцас хэрэглэл, тав тухтай амьдралын салшгүй нэг хэсэг. Иймд хүрээлэн буй орчноо хайрлаж, хамгаалах нь маш чухал.



ТӨСВИЙН ОНЦЛОГ

Орон нутагт агаар, орчны бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нэмэлт эх үүсвэр олгоно

Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлнэ.

Улаанбаатарт төв цэвэрлэх байгууламж 7 аймагт орон нутгийн цэвэрлэх байгууламж барина.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг хот суурины хог зайлуулах, устгах, цэвэрлэхэд бүрэн зарцуулна.

2019 онд хүрээлэн буй орчны чиглэлээр хэрэгжүүлэх томоохон арга хэмжээ;



Агаарын бохирдлыг бууруулах

Агаарын бохирдол бууруулах үйл ажиллагаанд **75.2 тэрбум**



Ипотекийн зээлийг зорилтот болгож, агаар, орчны бохирдлыг бууруулахад **115 тэрбум**

- Аймаг, нийслэл, хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан орон сууц худалдан авахад,
- Инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих зээлдэгчид олгоно.

Хог хаягдалыг бууруулах



Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2019 оноос эхлэн хот суурин газрын хог зайлуулах, устгах, цэвэрлэхэд зарцуулна. **4.8 тэрбум**

Байгаль орчныг хамгаалах



2019 оноос доорх 2 төрлийн орлогын тодорхой хувийг тухайн орон нутгийн агаар, орчны бохирдлыг бууруулахад зарцуулна

- Түүхий нүүрсний агаарын бохирдлын төлбөрийн 50% **21.0 тэрбум**
- Газрын тосны лицензийн төлбөрийн 30% **0.8 тэрбум**

Бүтээн байгуулалт

Төв цэвэрлэх байгууламж **40 тэрбум**



7 аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх **11 тэрбум**



Хатуу хог хаягдал ангилах, ялгах, боловсруулах үйлдвэр **3 тэрбум**




НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



Төсвийн зарлагын 4 төгрөг тутмын 1 нь нийгмийн хамгааллын зардалд зарцуулагдаж байна.

Ирэх онд тэтгэвэр нэмэгдэх үү?

Тиймээ, 2019 онд тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд зориулж 140.7 тэрбум төгрөг төсөвлөсөн.



2019 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ:

01

Нийгмийн халамжийн санг нэгдсэн удирдлагаар хангана.

03

“Хүүхдийн мөнгө”-ийг үргэлжлүүлэн олгоно.

02

Тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлнэ.

04

Насны хишгийг үргэлжлүүлэн олгоно.

Эдийн засгийн ангиллаар:

Урсгал зардал
2,860.0 тэрбум

Хөрөнгө оруулалт
29.9 тэрбум

Эргэн төлөгдөх цэвэр зээл
0.0 тэрбум

Үйл ажиллагааны чиглэлээр:

Нийгмийн даатгал
2,068.5 тэрбум

Нийгмийн халамж
726.1 тэрбум

Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага
3.8 тэрбум

Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр
61.6 тэрбум

Нийгмийн хамгааллын хөрөнгө оруулалт
29.9 тэрбум

НИЙТ САНХҮҮЖИЛТ

2,889.9 тэрбум **13.1%** 2018 оноос

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН



Эмээ, манай гэр бүл нийгмийн халамжаас тэтгэмж авдаг уу?



Тиймээ, миний хүү гэхэд л сар бүр хүүхдийн мөнгө авдаг. Эмээ нь харин өндөр настай учраас “Насны хишиг” авдаг шүү дээ.

Төрөл	2018 (тэрбум)	2019 (тэрбум)	Өөрчлөлт
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	205.1	218.9	▲ 13.8
Цалинтай ээж хөтөлбөр	96.8	96.8	-
Халамжийн тэтгэвэр	96.5	99.5	▲ 3.0
Халамжийн бусад хөнгөлөлт, үйлчилгээ	55.5	31.1	▼ 24.4
Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	42.2	42.2	-
Нөхцөлт мөнгөн тусламж	35.2	37.5	▲ 2.3
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж	29.4	29.4	-
Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	23.1	24.0 3.8	▲ 4.7
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	1.1 21.1	26.1	▲ 3.9
Насны хишиг	20.5	22.3	▲ 1.8
Жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж	19.8	18.1	▼ 1.7
Тэтгэвэр нэмэгдүүлэх эх үүсвэр	17.8	21.2	▲ 3.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж	12.3	12.3	-
Ахмад дайчин, алдар цолтой ахмад настны тэтгэмж	6.4	6.4	-
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	3.3	1.8	▼ 1.5
Бусад үйл ажиллагааны зардал	2.1	2.0	▼ 0.1
Цаатан иргэний тэтгэмж	0.4	0.6	▲ 0.2
Асрамжийн үйлчилгээ	0.2	0.2	-

Орон нутгийн төсвийн санхүүжилт

Улсын төсвийн санхүүжилт


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН



Эмээ, та сар бүр бас тэтгэвэр авдаг, түүнийг хаанаас өгдөг юм бэ?



Нийгмийн даатгалын сангаас өгдөг. Ажил хийж байгаа бүх хүн нийгмийн даатгал төлдөг. Эргээд хөдөлмөр эрхлэх боломжгүй болоход нь энэ сангаас олон төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг олгодог.



НИЙГМИЙН ДААТГАЛ ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?



Нийгмийн даатгалыг бүх хүн төлөх ёстой гэж эмээ хэлсэн, яагаад төлөх хэрэгтэй вэ?

Нийгмийн даатгал бол таныг өндөр наслах, өвдөх, ажилгүй болох зэрэг эрсдэлийг хуваалцах төрийн даатгалын тогтолцоо юм.



Та шимтгэл төлж нийгмийн даатгалд хамрагдсанаар:



Өвдвөл: хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж (өвдсөн хугацаанд)

АЖУУЛ
ГАРАА

Төрвөл: жирэмсэн, амаржсны тэтгэмж (төрөхийн өмнөх 2 сар, төрсний дараах 2 сард)



Ажилгүй болбол: ажилгүйдлийн тэтгэмж (ажилгүй байх 3 сард)



Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдвал: тахир дутуугийн тэтгэвэр



Үйлдвэрлэлийн осолд орвол: ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлууд

Нас барвал: оршуулгын тэтгэмж, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр



Тэтгэвэрт гарвал: Өндөр насны тэтгэвэр (насан туршдаа)



Нийгмийн даатгал бол Татвар биш. Та нийгмийн даатгалын шимтгэл төлсний хариуд тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсдэг. **Нийгмийн даатгал бол Халамж биш.** Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэдэд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгодог.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Эдийн засаг 2019 онд улам ихээр өснө гээд л байна. Энэ үнэн үү?

Тиймээ, 2019 онд хөдөө аж ахуй, уул уурхай, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд нийт 949.3 тэрбум төгрөг төсөвлөсөн. 2019 оны нийт төсөв, гол онцлогуудыг танд танилцуулбал:



2019 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ:

01 Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж, малыг эрүүлжүүлнэ.

03 Уул уурхайн судалгаа, шинжилгээний зардлыг нэмэгдүүлнэ.

02 Дэд бүтцийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийнэ.

04 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Эдийн засгийн ангиллаар:

Урсгал зардал
412.4 тэрбум

Хөрөнгө оруулалт
603.7 тэрбум

Эргэн төлөгдөх цэвэр зээл
-66.8 тэрбум

Үйл ажиллагааны чиглэлээр:

ХАА, газар тариалан
149.3 тэрбум

Эрчим хүч, уул уурхай
155.0 тэрбум

Зам тээвэр
306.1 тэрбум

Барилга
257.1 тэрбум

Худалдаа
2.5 тэрбум

Харилцаа холбоо
29.5 тэрбум

Хөдөлмөр эрхлэлт
49.8 тэрбум



ХӨДӨӨ АЖ АХУЙ



Хөдөө аж ахуй гэснээс манай авдаг нөгөө арьс ширний урамшуулал үргэлжлэх юм болов уу?



Үргэлжлэлгүй яахав. Өөр олон төрлийн ХАА-н урамшуулал байдаг гэдгийг та мэдэх үү? Шинээр сүү, сүүн бүтээгдэхүүний урамшуулал бий болсон. Энэ жил нийт 56.6 тэрбум төгрөгийг ХАА-н урамшуулалд олгоно.

0.5 тэрбум **▼ 337%** 2018 оноос

Жимс, жимсгэний тариалан

Жимсний аж ахуй эрхлэгч 5 жил хүртэлх хугацаанд хүүгүй зээл авна.

22.6 тэрбум **▲ 0%** 2018 оноос

Ноосны урамшуулал

Боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан ноосонд

- Нарийн, нарийвтар хонь, тэмээний ноос 1кг = 2,000 төгрөг
- Бүдүүн, бүдүүвтэр хонины ноос 1кг = 1,000 төгрөг

11.8 тэрбум **▲ 0%** 2018 оноос

Арьс, ширний урамшуулал

Боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан стандартад нийцсэн арьс ширэнд

- Бод малын 1 ширхэг арьс 15,000 төгрөг
- Бог малын 1 ширхэг арьс 3,000 төгрөг

12.9 тэрбум **▼ 15%** 2018 оноос

Улаанбуудайн урамшуулал

Гурилын үйлдвэр, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, улсын нөөцөд нийлүүлсэн хүнсний улаанбуудайд

- I - III ангилалд 1 тоннд 60,000 төгрөг
- IV ангилалд 1 тоннд 50,000 төгрөг

4.7 тэрбум **▲ 0%** 2018 оноос

Мах бэлтгэхэд олгох зээлийн хөнгөлөлт

Мах боловсруулах үйлдвэрийн мах бэлтгэхэд олгосон арилжааны банкны зээлийн 8-10%-иар улсаас хөнгөлөлт үзүүлдэг.


4.0 тэрбум **▲ ШИНЭ** 2018 оноос

Сүү, цагаан идээний урамшуулал

Стандартын шаардлага хангасан түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгоно.



ХАА-н урамшууллаас гадна мал эрүүлжүүлэх, газар тариалангийн бүс, бэлчээр хамгаалах арга хэмжээнд нилээд хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн.



60.8 тэрбум **▲ 42%** 2018 оноос

Мал аж ахуй, мал эрүүлжүүлэх




2.6 тэрбум **▼ 78%** 2018 оноос


Бэлчээр, тариалангийн хөрс хамгаалал

МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД (1990-2017)


Монгол Улсын хүн ам 1990 оноос хойш 1 саяар, өрхийн тоо 2 дахин, хүн амын дундаж наслалт 9.4 жилээр нэмэгдсэн байна.



Монгол Улсын эдийн засаг жил бүр өсч, нэг хүнд ногдох ДНБ 2017 онд 9 саяд хүрээд байна. Хатуу хучилттай замын нийт урт 2017 онд 7,552.9 км болсон. Ингэснээр нийслэлтэй 16 аймгийн төв хатуу хучилттай замаар холбогдоод байна.



Компьютерийн тоо (мянган)




Ердөө сүүлийн 30 жилийн хугацаанд улс орон минь асар хурдтай хөгжсөн байгаа биз дээ?


Аваа, таньг бага байхад тэгээд гар утас, интернэт, компьютер аль нь ч байгаагүй гэж үү?




Интернэт хэрэглэгч (мянган)




Үүрэн утас хэрэглэгч (мянган)



Автомашинны тоо (мянган)



Суурийн утасны тоо (мянган)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Зам, тээврийн хөгжлийн яам

Биднийг багад лааны гэрэлд хичээлээ хийдэг, саяхныг хүртэл Хөвсгөл аймагруу машинаар 2 өдөр явдаг байлаа. Өнөөдөр бараг бүх сум гэрэл, цахилгаантай болж, ихэнх аймгийн төвүүд нийслэлтэй засмал замаар холбогдоод сайхан болжээ.



